



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2023/23/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: <a href="http://www.bulgan@audit.gov.mn">www.bulgan@audit.gov.mn</a> Булган аймаг Булган сум 2023 он	Булган аймаг дахь ТАГ-н дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 89009802 Цахим хаяг: <a href="mailto:erdeneb@audit.gov.mn">erdeneb@audit.gov.mn</a> Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Утас: Цахим хаяг: Аудитор: Б.Золжаргал Утас: 90119931 Цахим хаяг: <a href="mailto:zoljargalb@audit.gov.mn">zoljargalb@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 101  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс 514.4 сая төгрөгөөр санхүүжигдэж гүйцэтгэл 508.7 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1.2 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 122.9 сая төгрөгөөр санхүүжигдэж 122.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

### Аудитын гол асуудал

1978 онд ашиглалтад орсон уурын зуухны барилгыг 2001 онд хөрөнгө дахин үнэлэхдээ үнэлгээ тогтоосон дүнгээр дахин орлогод бүртгэж тайлагнаж байсан алдааг 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд Засаг даргын тамгын

D:/bichighereg/2022A4toot

006020108

газрын даргын 2023 оны 03/44 тоот албан бичгээр хүсэлт гаргасныг хүлээн авч залруулсан.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>61,005,830.04</b>	<b>64,399,643.04</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	690,000.00	1,122,622.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,100,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	22,622.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	690,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	690,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	58,948,330.04	61,909,521.04
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	16,385,721.04	16,385,721.04
35110	Тусгай зориулалттай материал	16,385,721.04	16,385,721.04
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	35,494,609.00	39,105,800.00
35410	Бичиг хэргийн материал	458,800.00	872,000.00
35420	Аж ахуйн материал	31,032,809.00	34,484,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,003,000.00	4,003,000.00
35460	Хүнсний материал	-	(254,100.00)
35600	Мал амьтад	7,068,000.00	6,418,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	1,367,500.00	1,367,500.00
36100	Барааны нөөц	1,367,500.00	1,367,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,838,969,279.95</b>	<b>2,031,495,279.25</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,838,969,279.95	2,031,495,279.25
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,812,547,779.91	2,006,423,779.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,976,129,852.42	3,216,895,411.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,400,152,444.95)	(1,473,605,515.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,700,000.00	130,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,418,790.98)	(47,689,624.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119,876,224.02	139,072,024.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,332,422.47)	(74,205,375.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	145,028,487.75	145,028,487.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,804,292.48)	(29,692,796.11)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	400,466.60	400,466.60
39217	Ном	120,700.00	120,700.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	26,421,500.04	25,071,500.04
39301	Програм хангамж	5,100,000.00	5,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(762,499.96)	(2,112,499.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,084,000.00	22,084,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,899,975,109.99</b>	<b>2,095,894,922.29</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>286,452.28</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	286,452.28
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	286,452.28
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	263,830.28
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	22,622.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	22,622.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,877,891,109.99</b>	<b>2,095,608,470.01</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,877,891,109.99	2,095,608,470.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	620,338,407.95	642,422,407.95
51101	Өмч: - төрийн	620,338,407.95	642,422,407.95
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	641,756,900.35	875,918,900.23
51210	Өмнөх үеийн үр дүн	641,756,900.35	680,285,540.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	195,633,360.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	615,795,801.69	577,267,161.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,877,891,109.99</b>	<b>2,095,894,922.29</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>752,310,469.78</b>	<b>440,513,433.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>243,889,910.00</b>	<b>318,291,778.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>243,889,910.00</b>	<b>318,291,778.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>243,889,910.00</b>	<b>121,462,784.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,712,824.00	6,973,284.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	238,177,086.00	114,489,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	196,828,994.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>508,420,559.78</b>	<b>122,221,655.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>63,860,550.00</b>	<b>122,221,655.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,980,000.00	108,603,494.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	898,550.00	4,065,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,982,000.00	9,553,001.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>444,560,009.78</b>	<b>0.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	444,560,009.78	0.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>618,590,764.50</b>	<b>735,893,452.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>618,590,764.50</b>	<b>735,893,452.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>591,843,889.76</b>	<b>706,986,475.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>236,187,344.00</b>	<b>247,946,565.00</b>
210101	Үндсэн цалин	176,778,528.00	180,693,254.69
210102	Нэмэгдэл	52,691,538.00	48,943,616.25
210104	Урамшуулал	0.00	16,145,270.26
210105	Гэрээт ажлын хөлс	6,717,278.00	2,164,423.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,759,913.50</b>	<b>33,370,185.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,448,061.58	23,212,709.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,327,962.98	2,592,635.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,862,370.48	2,056,867.94
210204	Ажилгүйдлийн даатгал	465,592.50	501,480.82
210205	Эрүүл мэндийн даатгал	4,655,925.96	5,006,492.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,212,899.70</b>	<b>52,301,721.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,499,999.70	10,869,961.00
210302	Түлш, халаалт	37,712,900.00	41,431,760.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,632,197.00</b>	<b>51,628,484.10</b>
210401	Бичиг хэрэг	3,324,585.00	2,056,760.00
210402	Тээвэр, шатахуун	9,089,230.00	36,206,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,995,430.00	2,446,629.10
210404	Ном, хэвлэл	45,000.00	39,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,769,852.00	9,832,055.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	756,100.00	1,047,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	652,000.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>366,200.00</b>	<b>880,000.00</b>
210502	Хоол, хүнс	0.00	336,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	366,200.00	544,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,322,430.00</b>	<b>19,527,872.00</b>
210604	Урсгал засвар	10,322,430.00	19,527,872.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,971,000.00</b>	<b>4,696,000.00</b>

210702	Дотоод албан томилолт	1,971,000.00	4,696,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,333,445.00</b>	<b>737,064.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,820.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	353,750.00	214,725.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	749,875.00	285,435.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	79,000.00	108,400.00
210807	Газрын төлбөр	0.00	128,504.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>246,058,460.56</b>	<b>295,898,583.61</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,612,372.92	139,741,722.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	311,570.00	1,023,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	143,134,517.64	155,133,860.98
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,746,874.74</b>	<b>28,906,976.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,853,300.00</b>	<b>28,842,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	11,880,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,631,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,221,600.00	16,962,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,893,574.74</b>	<b>64,176.37</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,893,574.74	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	64,176.37
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>133,719,705.28</b>	<b>-295,380,019.07</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>29,899,730.54</b>	<b>17,773,833.72</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	4,131,230.54	17,773,833.72
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	25,768,500.00	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>103,819,974.74</b>	<b>-313,153,852.79</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>514,133,383.78</b>	<b>129,907,561.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,712,824.00</b>	<b>6,973,284.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,712,824.00</b>	<b>6,973,284.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>5,712,824.00</b>	<b>6,973,284.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,712,824.00	6,973,284.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>508,420,559.78</b>	<b>122,934,277.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>63,860,550.00</b>	<b>122,911,655.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,980,000.00	109,293,494.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	898,550.00	4,065,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,982,000.00	9,553,001.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>444,560,009.78</b>	<b>0.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	444,560,009.78	0.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>22,622.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	22,622.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>485,067,183.78</b>	<b>619,498,973.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>485,067,183.78</b>	<b>619,498,973.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>457,252,809.04</b>	<b>590,569,375.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>236,187,344.00</b>	<b>249,080,243.10</b>
210101	Үндсэн цалин	176,778,528.00	181,826,932.79
210102	Нэмэгдэл	52,691,538.00	48,943,616.25
210104	Урамшуулал	0.00	16,145,270.26
210105	Гэрээт ажлын хөлс	6,717,278.00	2,164,423.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,554,814.34</b>	<b>33,106,355.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,242,962.42	22,948,879.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,327,962.98	2,592,635.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,862,370.48	2,056,867.94
210204	Ажилгүйдлийн даатгал	465,592.50	501,480.82
210205	Эрүүл мэндийн даатгал	4,655,925.96	5,006,492.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,212,899.70</b>	<b>52,039,221.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,499,999.70	10,607,461.00
210302	Түлш, халаалт	37,712,900.00	41,431,760.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,334,617.00</b>	<b>40,199,416.00</b>
210401	Бичиг хэрэг	2,653,285.00	2,422,650.00
210402	Тээвэр, шатахуун	9,089,200.00	24,322,173.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,995,430.00	2,093,150.00
210404	Ном, хэвлэл	160,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,436,702.00	10,261,443.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,506,600.00</b>	<b>1,136,000.00</b>
210502	Хоол, хүнс	0.00	336,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,506,600.00	800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,239,550.00</b>	<b>56,999,963.00</b>
210604	Урсгал засвар	14,239,550.00	56,999,963.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,971,000.00</b>	<b>4,696,000.00</b>

210702	Дотоод албан томилолт	1,971,000.00	4,696,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,182,625.00</b>	<b>832,664.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	353,750.00	214,725.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	749,875.00	349,435.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	79,000.00	140,000.00
210807	Газрын төлбөр	0.00	128,504.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>102,063,359.00</b>	<b>152,479,512.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,563,789.00	150,679,512.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	499,570.00	1,800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,814,374.74</b>	<b>28,929,598.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,230,800.00</b>	<b>28,842,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	11,880,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,631,700.00	15,962,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,599,100.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,583,574.74</b>	<b>86,798.37</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,893,574.74	22,622.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	690,000.00	64,176.37
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>29,066,200.00</b>	<b>-489,591,412.81</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>29,066,200.00</b>	<b>19,195,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,066,200.00</b>	<b>19,195,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>29,066,200.00</b>	<b>19,195,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,066,200.00	19,195,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-29,066,200.00</b>	<b>-19,195,800.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>-508,787,212.81</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>642,422,407.95</b>	<b>615,795,801.69</b>	<b>537,936,925.61</b>	<b>1,796,155,135.25</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>642,422,407.95</b>	<b>615,795,801.69</b>	<b>537,936,925.61</b>	<b>1,796,155,135.25</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	103,819,974.74	103,819,974.74
10	<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>642,422,407.95</b>	<b>615,795,801.69</b>	<b>641,756,900.35</b>	<b>1,899,975,109.99</b>
11	<b>2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	<b>642,422,407.95</b>	<b>615,795,801.69</b>	<b>641,756,900.35</b>	<b>1,899,975,109.99</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	38,528,639.86	38,528,639.86
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>642,422,407.95</b>	<b>615,795,801.69</b>	<b>680,285,540.21</b>	<b>1,938,503,749.85</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-38,528,639.86	0.00	-38,528,639.86
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	195,633,360.02	195,633,360.02
20	<b>2022 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл</b>	<b>642,422,407.95</b>	<b>577,267,161.83</b>	<b>875,918,900.23</b>	<b>2,095,608,470.01</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>544,532,200.00</b>	<b>515,760,496.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>544,532,200.00</b>	<b>515,760,496.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>515,689,400.00</b>	<b>486,917,696.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>270,447,800.00</b>	<b>247,504,337.10</b>
210101	Үндсэн цалин	217,175,600.00	181,826,932.79
210102	Нэмэгдэл	53,272,200.00	48,943,616.25
210104	Урамшуулал	0.00	14,569,364.26
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	2,164,423.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,782,100.00</b>	<b>32,931,355.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,007,400.00	22,773,879.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,706,800.00	2,592,635.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,165,300.00	2,056,867.94
210204	Ажилгүйдлийн даатгал	541,400.00	501,480.82
210205	Эрүүл мэндийн даатгал	5,361,200.00	5,006,492.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,423,400.00</b>	<b>52,039,221.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,100,000.00	10,607,461.00
210302	Түлш, халаалт	43,323,400.00	41,431,760.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,384,100.00</b>	<b>34,250,016.00</b>
210401	Бичиг хэрэг	2,394,200.00	2,392,650.00
210402	Тээвэр, шатахуун	18,409,900.00	18,402,773.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,100,000.00	2,093,150.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,380,000.00	10,261,443.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>800,000.00</b>	<b>800,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>76,200,000.00</b>	<b>76,195,763.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,200,000.00	19,195,800.00
210604	Урсгал засвар	57,000,000.00	56,999,963.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>4,784,000.00</b>	<b>4,696,000.00</b>
210702	Дотоод албан томилот	4,784,000.00	4,696,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,118,000.00</b>	<b>832,664.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	420,000.00	214,725.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	365,000.00	349,435.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	140,000.00
210807	Газрын төлбөр	193,000.00	128,504.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>37,750,000.00</b>	<b>37,668,340.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,950,000.00	35,868,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,000.00	1,800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,842,800.00</b>	<b>28,842,800.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,842,800.00</b>	<b>28,842,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,880,000.00	11,880,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,962,800.00	15,962,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>544,532,200.00</b>	<b>515,760,496.81</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>485,785,000.00</b>	<b>508,787,212.81</b>
320001	Орон нутгийн төсвөөс	485,785,000.00	508,787,212.81
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>58,747,200.00</b>	<b>6,973,284.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,848,000.00	6,973,284.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	54,899,200.00	0.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>122,911,655.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>122,911,655.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>122,847,478.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,575,906.00</b>
210104	Урамшуулал	1,575,906.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>175,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	175,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,949,400.00</b>
210401	Бичиг хэрэг	30,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,919,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>336,000.00</b>
210502	Хоол, хүнс	336,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>114,811,172.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,811,172.63
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>64,176.37</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>64,176.37</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	64,176.37
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>122,911,655.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>122,911,655.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,293,494.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,065,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,553,001.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Гурванбулаг сумын ЗДТГ нь нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн стратеги төлөвлөлтөд тулгуурлан төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг тооцох гэж зорилтоо тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант онд тухайн байгууллагад мөрддөг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоол, 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолд тус тус өөрчлөлт орсон байна.

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Сангийн сайдын 2019 оны 05 дугаар тогтоол, Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар батлагдсан албан томилолтын зардлын тарифт өөрчлөлт оруулах тухай тушаал, Төрийн болон албаны нууцын тухай хуулиудад өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар батлагдсан аймгийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрддөг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 195,919.8 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	690.0	1,122.62	432.6
Бараа материал	60,315.8	63,277.0	2,961.2
Үндсэн хөрөнгө	1,838,969.2	2,031,495.2	192,526.0
Нийт хөрөнгө	1,899,975.1	2,095,894.9	195,919.8
Өр төлбөр	0.0	268.4	268.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,899,975.1	2,095,608.4	195,633.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,899,975.1	2,095,894.9	195,919.8

Дээрх хүснэгтээс харахад:

- ✚ Авлагын үлдэгдэл 1,122.6 мянган төгрөг нь цалингийн урьдчилгааны авлага 1,100.0 мянга, ажилтны ХЧТА-ын тэтгэмж олгож амжилгүй татан төвлөрүүлсэн 22.6 мянган төгрөгийн үлдэгдэл байна.
- ✚ Бараа материалын дансны үлдэгдэл 63,277.0 мянган төгрөг болж өмнөх оноос 2,961.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авч зарцуулагдаагүй аж ахуйн материалын үлдэгдлээс шалтгаалжээ.
- ✚ Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,031,495.2 мянган төгрөг болж өмнөх оноос 192,526.0 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-н хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө 114,039.5 мянга, ахуйн үйлчилгээний барилгын их засвар 196,828.9 мянга, уурын зуухны барилгын их засвар 20,000.0 мянга, ТГ-ын 2 давхар барилга 14,269.4 мянган төгрөгийн их засварыг хүлээн авч хөрөнгийг капиталжуулж, 19,195.8 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл худалдаж авсан. Мөн тайлант онд 54,472.3 мянган төгрөгийн барилга байгууламж, 18,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл акталж устгасан.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 428,412.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 105,616.6 мянган төгрөгөөр бууруулж 322,796.1 мянган төгрөгөөр баталсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг Гурванбулаг сумын ИТХ-н 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 06/04 тоот тогтоолоор 322,796.1 мянган төгрөгөөр баталсныг, 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 8-р хуралдааны 08/10 тогтоолоор 422,124.3 мянган төгрөг болгон 99,328.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 508,787.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 6,973.3 мянган төгрөгөөр тус тус санхүүжигдэж зарцуулагдаагүй үлдэгдэл 5,655.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 510,105.1 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 5,655.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	515,700.5	510,105.1	5,655.3	98.9%
	Нийт	515,700.5	510,105.1	5,655.3	98.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	122,911.6	122,847.5	64.1	99.9%
	Нийт	122,911.6	122,847.5	64.1	99.9%

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрээр задалбал:

- ✚ Цэвэр орчин, цэмцгэр Булган аяны хүрээнд 2,500.0 мянга,
- ✚ ХАА-н тооллого, сургалт судалгааны зардалд 4,065.1 мянга,
- ✚ Төрөөс усны хөнгөлөлт 2,690.0 мянга,
- ✚ Хортон, мэрэгч устгалын зардал 7,839.9 мянга,
- ✚ Ахуйн үйлчилгээний барилгын их засварын санхүүжилт 98,263.6 мянга,
- ✚ Өмнөх оны төвлөрүүлсэн үлдэгдэл 690.0 мянга,
- ✚ Өвсний үнэ 200.0 мянга,
- ✚ Авто худгийн усны орлого 7,533.3 мянга,

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь ТАГ-н аудитор Б.Золжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь ТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/27 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлаас буюу 764,324.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,464.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 9,171.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоолгүй ажиллаж 5,655.3 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 26 удаагийн 342,481,957.0 төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлэхээс 11 удаагийн 154,467,600.0 төгрөгийн орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 удаагийн 134,387,442.0 төгрөгийн зарлага мэдээлэхээс 5 удаагийн 41,930,240.0 төгрөгийн

зарлага, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 68 удаагийн 45,784,500.0 төгрөгийн тушаал, шийдвэр мэдээлэхээс 5 удаагийн 16,912,800.0 төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт: 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	4,219.9	3	4,219.9	100%
Зөвлөмж	2	0.0	2	0.0	100%
Албан шаардлага	5	65,788.5	5	38,815.2	59%
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>70,008.4</b>	<b>10</b>	<b>43,035.1</b>	<b>86%</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээг хуулийн хугацаанд, үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх албан шаардлага хүргүүлсэн боловч 2022 онд шилэн дансны цахим системд мэдээлэх нийт 522,653.9 мянган төгрөгийн ажил гүйлгээ мэдээлэхээс 309,343.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлж, 213,310.6 мянган төгрөгийн мэдээг мэдээлэлгүй орхисон тул биелэлтийг 59 хувьтай гэж дүгнэлээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу үйл ажиллагааны зардлыг хуримтлуулан бүртгэсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон 7,952.7 мянга, барилга байгууламж давхар бүртгэсэн 134,001.6 мянган төгрөгийн 1 бүртгэл, тооцооны данстай холбоотой 1,409.0 мянган төгрөгийн 3 ажил гүйлгээ, бараа материалын тайлагналтай холбоотой 14,629.0 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээ, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 20,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, нийт 177,992.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд зарцуулсан 35,075,290.0 төгрөгийн шатахууны зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг 3,638,447.0 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэтрүүлэн зарцуулсан шатахууны үнийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоох

### 5.2 Албан шаардлага

Тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/13 тоот тушаалаар 2022 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комисс 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон боловч тооллогыг үнэн, зөв бодитой хийж баталгаажуулаагүй.

Энэ нь ННБ-ийн тухай хуулийн 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.2-д “бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих, комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай хийж үр дүнг бүртгэлд тусган биелэлтийг ирүүлэх, албан шаардлага хүргүүлэх

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, ННБ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон	1	7,952.7					1	7,952.7				
Барилга байгууламж давхар бүртгэсэн	1	134,001.6					1	134,001.6				
Тооцооны данстай холбоотой	3	1,409.0					3	1,409.0				
Бараа материалын тайлагналтай холбоотой	2	14,629.0					2	14,629.0				
Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой	1	20,000.0					1	20,000.0				
Дүн	8	177,992.5					8	177,992.5				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жишиг нормоос хэтрүүлэн зарцуулсан	1	3,638.4	1	3,638.4								
Хөрөнгийн тооллого бодитой хийж, баталгаажуулаагүй	1	0.0			1	0.0						
Дүн	2	3,638.4	1	3,638.4	1	0.0						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/		Зөвлөмж	
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны мэдээ мэдээлээгүй			1	213,310.6			1	213,310.6		
Дүн			1	213,310.6			1	213,310.6		